



**БОГД БАНК**

ИТГЭЛ ТҮГЭЭНЭ

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

Огноо: 2024.04.29

№ 24/01

Улаанбаатар хот

Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.7, Богд банкны дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3-д заасныг тус тус удирдлага болгон Богд банкны 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 2024 оны 04-р сарын 29-ний өдрийн №2 тоот шийдвэрийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ нь:**

1. “Богд банк” ХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан “хангалттай сайн” гэх дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.
2. Энэхүү хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж нийтэд мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.БОЛДХУЯГ



**БОГД БАНК**  
ИТГЭЛ ТҮГЭЭНЭ

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

Огноо: 2024.04.29

№ 24/02

Улаанбаатар хот

Компанийн ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны тайлантай танилцаж,  
ТУЗ-ийн 2024 оны зардлын төсвийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, 62.1.15, 62.1.16, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.6, 29.2.9, Богд банкны дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.7, 7.8.8, 7.8.9-д заасныг тус тус удирдлага болгон Богд банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, 2024 оны зардлын төсөвтэй танилцсаны үндсэн дээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 2024 оны 04-р сарын 29-ний өдрийн №2 тоот шийдвэрийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ** нь:

1. “Богд банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэж, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг энэхүү шийдвэрийн хавсралтаар баталсугай.
2. Энэхүү хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж нийтэд мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.БОЛДХУЯГ

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

Огноо: 2024.04.29

№ 24/03

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж,  
дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 29 дүгээр зүйлийн 29.2.1, Богд банкны дүрмийн 7 дугаар зүйлийн 7.7.1-д заасныг тус тус удирдлага болгон компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 2024 оны 04-р сарын 29-ний өдрийн №2 тоот шийдвэрийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ нь:**

1. “Богд банк” ХК-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.3-д дараах заалтыг шинээр нэмж, дүрмийн шинэчилсэн найруулгыг энэхүү шийдвэрийн хавсралтаар баталсугай.  
“3.3.11 Үнэт металл, эрдэнийн чулуу худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах;”
2. Энэхүү хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж нийтэд мэдээлэх, улсын бүртгэлд бүртгүүлж баталгаажуулахыг хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.БОЛДХУЯГ